

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/22/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2025 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болормаа Утас: 70357855 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 76

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Ч.ЦЭВЭГМЭД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Ээлжийн амралтын нөхөн олговор авсан 4 албан хаагчид 1,317.9 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.
2. Тайлант онд нягтлан бодогч, сургалтын менежер, гагнуурын багш, арга зүйч гэсэн 4 ажилтанд спортын мастер, олон улсын хэмжээний спортын мастер цолны нэмэгдэлд 5,724.7 мянган төгрөгийг цалингийн нэмэгдлээр тооцон олгосон.
3. Тайлант онд 8 алба хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд нь давхардуулан 225.0 мянган төгрөгийг илүү олгосон.
4. Тайлант оны 05 дугаар сард вебсайт хийлгэхээр "Эго софт" ХХК-тай гэрээ байгуулан 5,000.0 мянган төгрөгийн төлбөрийг 100 хувь шилжүүлсэн боловч

одоог хүртэл тухайн хөрөнгийг хүлээж аваагүй, бүртгэл тайланд тусгалгүй, шууд зарлагдсан.

5. Тайлант онд захирлын А/62 дугаар тушаалаар "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн 3 ажилтныг үндсэн цалингийн 40 хувиар буюу нийт 1,655.6 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон.
6. Байгууллагын захирлын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 3,555.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон.
7. Тайлант оны 12 дугаар сард алба хаагчдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан шагнал урамшуулалд 27,410.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон.
8. Тайлант онд 82,410.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 285,931.3 мянган төгрөгийн бараа материал, нийт 368,341.3 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг нийт өртгөөр нь зарлалгүй, шууд худалдан авсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 312 дугаар тогтоолоор Орхон аймгийн Мэргэжлийн Сургалт-Үйлдвэрлэлийн төвийн 1,008,966.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 491,687.9 мянган төгрөгийн бараа материал, Орхон аймаг дахь Хөдөө Аж Ахуйн Мэргэжлийн Сургалт-Үйлдвэрлэлийн төвийн 951,569.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 57,397.0 мянган төгрөгийн бараа материалыг балансаас балансад шилжүүлж, Орхон аймаг дахь Политехник коллежийн санхүүгийн тайланд нийт 13,827,102.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 549,085.0 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Орхон аймаг дахь Политехник коллеж нь тайлант онд дотуур байрны хоолны зардал 130,173.0 мянга, машин тоног төхөөрөмж 190,427.0 мянга, тавилга эд хогшил 190,427.0 мянга, урсгал засварын материал, хичээл ажлын дадлагын материалыг 285,931.3 мянган төгрөгөөр худалдан авахдаа хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Бусад асуудал

Орхон аймаг дахь Политехник коллежийн захирлын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 үндсэн хэсэг, 2 арга хэмжээний хүрээнд нийт 11 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцэст 93.56 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature]

П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	<u>937,104,032.09</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	398,449,765.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	398,449,765.24
3121	Төгрөг	-	398,449,765.24
31211	Төрийн сангийн харилцах	-	393,115,765.24
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	5,334,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	538,654,266.85
351	Түүхий эд материал	-	483,958,116.85
35110	Тусгай зориулалттай материал	-	483,193,616.85
35130	Эм боох материал	-	764,500.00
354	Хангамжийн материал	-	54,696,150.00
35410	Бичиг хэргийн материал	-	4,014,950.00
35420	Аж ахуйн материал	-	857,400.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,295,000.00
35450	Барилгын засварын материал	-	2,597,000.00
35460	Хүнсний материал	-	12,306,350.00
35470	Бусад хангамжийн материал	-	33,625,450.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	<u>9,936,826,950.52</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	9,936,826,950.52
392	Биет хөрөнгө	-	8,852,913,478.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	8,539,375,166.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,236,916,650.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	46,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(46,149,999.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	2,869,296,146.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,091,426,078.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	437,953,625.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(243,201,158.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	642,497,660.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(464,797,014.56)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	294,590,964.00
39217	Ном	-	105,390,817.91
393	Биет бус хөрөнгө	-	1,083,913,471.68
39301	Програм хангамж	-	61,518,261.40
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(40,340,969.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	1,062,736,180.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	=	<u>10,873,930,982.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>778,556.42</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	778,556.42
413	Өглөг	-	778,556.42

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	778,556.42
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	=	10,873,152,426.19
51	Засгийн газрын хувь оролцоо	-	10,873,152,426.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	3,077,231,430.31
51101	Өмч: - төрийн		3,077,231,430.31
512	Хуримтлагдсан үр дүн	-	4,850,111,940.01
51210	Өмнөх үеийн үр дүн	-	(6,023,040,486.18)
51220	Тайлант үеийн үр дүн	-	10,873,152,426.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	2,945,809,055.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	=	10,873,930,982.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	17,836,749,236.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	11,328,358,723.51
120	Нийтлэг татварын бус орлого	-	11,328,358,723.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	11,311,864,723.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,165,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	320,349,749.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	10,966,349,973.91
120009	Бусад орлого	-	16,494,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	6,508,390,513.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	6,259,948,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	6,259,948,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	37,228,313.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	37,228,313.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	211,214,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	211,214,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	6,963,596,810.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	6,963,596,810.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	6,657,349,233.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	4,229,170,454.80
210101	Үндсэн цалин	-	2,320,360,672.47
210102	Нэмэгдэл	-	1,244,475,455.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	420,347,256.55
210104	Урамшуулал	-	243,987,069.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	527,366,466.48
210201	Тэтгэврийн даатгал	-	406,882,103.26
210202	Тэтгэмжийн даатгал	-	19,106,948.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	10,057,249.24
210204	Ажилгүйдлийн даатгал	-	9,105,304.13

210205	Эрүүл мэндийн даатгал	-	82,214,861.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	206,673,573.36
210301	Гэрэл, цахилгаан	-	53,480,968.00
210302	Түлш, халаалт	-	72,531,217.29
210303	Цэвэр, бохир ус	-	44,911,388.07
210304	Байрны түрээс	-	35,750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	108,872,138.50
210401	Бичиг хэрэг	-	12,809,400.00
210402	Тээвэр, шатахуун	-	19,825,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,856,206.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	58,680,932.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	13,700,600.00
2105	Нормативт зардал	-	109,132,019.81
210502	Хоол, хүнс	-	103,615,631.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,516,388.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	438,178,663.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,007,800.00
210604	Урсгал засвар	-	434,170,863.00
2107	Томилолт, зочны зардал	-	6,430,700.00
210702	Дотоод албан томилолт	-	6,430,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,031,525,217.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	203,861,810.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	157,428,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	670,235,007.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	306,247,576.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	278,608,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	92,164,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	177,662,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,782,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	27,639,076.64
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	27,639,076.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	10,873,152,426.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	≡	10,873,152,426.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	6,870,399,262.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	362,008,749.60
120	Нийтлэг татварын бус орлого	-	362,008,749.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	362,008,749.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,165,000.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	320,349,749.60
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	16,494,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	6,508,390,513.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	6,259,948,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	6,259,948,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	37,228,313.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	37,228,313.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	211,214,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	211,214,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	6,281,522,497.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	6,281,522,497.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,980,556,920.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	4,229,420,454.80
210101	Үндсэн цалин	-	2,320,610,672.47
210102	Нэмэгдэл	-	1,244,475,455.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	420,347,256.55
210104	Урамшуулал	-	243,987,069.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	526,337,910.06
210201	Тэтгэврийн даатгал	-	405,853,546.84
210202	Тэтгэмжийн даатгал	-	19,106,948.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	10,057,249.24
210204	Ажилгүйдлийн даатгал	-	9,105,304.13
210205	Эрүүл мэндийн даатгал	-	82,214,861.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	206,673,573.36
210301	Гэрэл, цахилгаан	-	53,480,968.00
210302	Түлш, халаалт	-	72,531,217.29
210303	Цэвэр, бохир ус	-	44,911,388.07
210304	Байрны түрээс	-	35,750,000.00
2105	Нормативт зардал	-	105,836,500.00
210502	Хоол, хүнс	-	105,836,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	383,528,763.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	56,791,300.00
210604	Урсгал засвар	-	326,737,463.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	528,759,719.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	327,256,519.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	201,503,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	300,965,576.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	273,326,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	92,164,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	177,662,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	27,639,076.64

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	27,639,076.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	588,876,765.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	190,427,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	190,427,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	190,427,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	190,427,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(190,427,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	398,449,765.24
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	398,449,765.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(6,023,040,486.18)	(6,023,040,486.18)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(6,023,040,486.18)	(6,023,040,486.18)
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	2,945,809,055.87	-	2,945,809,055.87
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	3,077,231,430.31	-	-	3,077,231,430.31
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	10,873,152,426.19	10,873,152,426.19
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,077,231,430.31	2,945,809,055.87	4,850,111,940.01	10,873,152,426.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,824,626,400.00	5,871,831,584.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,824,626,400.00	5,871,831,584.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,551,299,900.00	5,598,505,084.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,367,332,400.00	4,229,420,454.80
210101	Үндсэн цалин	2,435,554,500.00	2,320,610,672.47
210102	Нэмэгдэл	1,578,883,600.00	1,244,475,455.96

210103	Унаа хоолны хөнгөлөлт	352,894,300.00	420,347,256.55
210104	Урамшуулал	-	243,987,069.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	543,491,200.00	526,337,910.06
210201	Тэтгэврийн даатгал	369,573,900.00	405,853,546.84
210202	Тэтгэмжийн даатгал	43,479,300.00	19,106,948.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,739,700.00	10,057,249.24
210204	Ажилгүйдлийн даатгал	21,739,700.00	9,105,304.13
210205	Эрүүл мэндийн даатгал	86,958,600.00	82,214,861.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	234,252,600.00	-
210301	Гэрэл, цахилгаан	51,420,700.00	-
210302	Түлш, халаалт	67,572,500.00	-
210303	Цэвэр, бохир ус	37,259,400.00	-
210304	Байрны түрээс	78,000,000.00	-
2105	Нормативт зардал	130,173,000.00	105,836,500.00
210502	Хоол, хүнс	130,173,000.00	105,836,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,386,200.00	206,360,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	56,805,100.00	56,791,300.00
210604	Урсгал засвар	293,581,100.00	149,569,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	925,664,500.00	530,549,719.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	437,140,600.00	329,046,519.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	488,523,900.00	201,503,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	273,326,500.00	273,326,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	92,164,500.00	92,164,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	177,662,000.00	177,662,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,442,424,349.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	6,096,909,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	6,096,909,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	345,514,749.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,165,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	320,349,749.60
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		398,449,765.24

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 490,591.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Ажилчидтай холбоотой авлага 313,114.5 мянган төгрөг илүү илэрхийлэгдсэн байсныг аудитын явцад залруулан бүртгэсэн.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн “Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал” 177,477.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэнийг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 413,229.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 6,543.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 406,686.6 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Ээлжийн амралтын нөхөн олговор авсан 4 албан хаагчид илүү цалин 1,317.9 мянган төгрөг, 8 алба хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд нь давхардуулан 225.0 мянга, вебсайт хийлгэхээр “Эго софт” ХХК-тай гэрээ байгуулан төлбөр 5,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч одоог хүртэл тухайн хөрөнгийг хүлээж аваагүй зэрэг 3 зөрчилд 6,543.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулалд 3,555.0 мянган төгрөг олгосон, алба хаагчдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан шагнал урамшуулалд 27,410.0 мянган төгрөг олгосон, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 368,341.3 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, байгууллагын бүтцэд батлагдаагүй “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 3 гишүүнийг үндсэн цалингийн үндсэн цалингийн 40 хувиар буюу нийт 1,655.6 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон, сургалтын менежер, гагнуурын багш, арга зүйч гэсэн 4 ажилтанд спортын мастер, олон улсын хэмжээний спортын мастер цолны нэмэгдэлд 5,724.7 мянган төгрөгийг олгосон зэрэг 5 зөрчилд 406,686.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” хэсэгт 2024 оны 1, 2, 3, 6, 7 саруудад мэдээлэл огт оруулаагүй, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд 5,470,649.7 мянган төгрөгийн 108 ажил гүйлгээнээс

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

252,724.9 мянган төгрөгийн 14 ажил гүйлгээ мэдээлж, 5,217,924.8 мянган төгрөгийн 94 ажил гүйлгээ мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, цаг хугацаанд нь мэдээлж байх.

тухайн хөрөнгийг хүлээж аваагүй, бүртгэл тайланд тусгалгүй, шууд зарлагдсан байна												
Тайлант онд захирлын А/62 дугаар тушаалаар "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн 3 ажилтныг үндсэн цалингийн 40 хувиар буюу нийт 1,655,600 төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон.	1	1,655.6			1	1,655.6						
Байгууллагын захирлын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 3,555,000 төгрөгийн балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна	1	3,555.0			1	3,555.0						
Тайлант оны 12 дугаар сард алба хаагчдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан шагнал урамшуулалд 27,410,030 төгрөгийг цалингийн зардлаас олгосон байна	1	27,410.0			1	27,410.0						
Тайлант онд 82,410.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 285,931.3 мянган төгрөгийн бараа материал, нийт 368,341.3 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг нийт өртгөөр нь зарлалгүй, шууд худалдан авсан байна.	1	368,341.3			1	368,341.3						
Дүн	8	413,229.6	3	6,543.0	5	406,686.6						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" хэсэгт 2024 оны 1, 2, 3, 6, 7 саруудад мэдээлэл огт оруулаагүй, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд 5,470,649.7 мянган төгрөгийн 108 ажил гүйлгээнээс 252,724.9 мянган төгрөгийн 14 ажил гүйлгээ мэдээлж, 5,217,924.8 мянган төгрөгийн 94 ажил гүйлгээ мэдээлээгүй орхигдуулсан байна.	1	-					1	-

Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-					-	-
Нийт дүн	1	-					1	-